

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДААТГАЛЫН ГАЗАР**

**ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2010 ОНЫ
САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХОРООНЫ ГИШҮҮН

Б.ШАРАВСАМБУУ

ХОРООНЫ ГИШҮҮН

Д.ДҮГЭРЖАВ

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Х.БУМ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА

С.ГАНБОЛД

ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА

П.ЦЭРЭНДЭЖИД

БОЛОВСРУУЛСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ

Э.ЭРДЭНЭТУЯА

УЛААНБААТАР ХОТ
2010.02.16

ГАРЧИГ

- I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- II. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ
- III. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- IV. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- V. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- VI. ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- VII. ДААТГАГЧ АШИГТ АЖИЛЛАГАА\
- VIII. ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- IX. ДАВХАР ДААТГАЛ
- X. ДААТГУУЛАГЧДЫН ТОО
- XI. ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ
- XII. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ
- XIII. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ
- XIV. ОЛОН УЛСЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ
- XV. ДҮГНЭЛТ

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2010 ОНЫ САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2010 онд арилжааны даатгалын салбарт ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компани (цаашид “даатгагч” гэх), тэдгээрийн орон нутаг дахь 138 даатгалын салбар, 2061 даатгалын төлөөлөгч иргэн, даатгалын зуучлагч 9 компани, даатгалын хохирол үнэлэгч 6 байгууллага, даатгалын актуарч 12 хувь хүн, даатгалын аудитын 28 компани, нийт 2133 даатгалын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигч хуулийн этгээд даатгалын зэх зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан байна (Хүснэгт-1).

Хүснэгт-1

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

д/д	Даатгалын оролцогч	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
1	Даатгагч /Даатгалын компанийн салбар/	22 /48/	15 /91/	16 /120/	18 /129/	17 /138/
2	Даатгалын төлөөлөгч	224	690	1 167	1 676	2061
3	Даатгалын зуучлагч	-	2	4	5	9
4	Даатгалын хохирол үнэлэгч	-	-	-	2	6
5	Актуарч	-	-	9	10	12
6	Даатгалын аудиторч	-	-	15	27	28
	Бүгд	246	707	1211	1738	2133

Тайлант онд “Моннис” ХХК-д ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Ренессанс групп” ХХК, “Лоялти солюшн” ХХК, “Жомолхари” ХХК, “Монголиан интернэшнл брокерс” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Вендо” ХХК, “Гэрэгэ эстимейт” ХХК, “Файн эстимейт” ХХК, “Мега марз” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл тус тус шинээр олгосон.

Мөн түүнчлэн “Соёмбо инк даатгал” ХХК нь “Түшиг даатгал” ХХК-тай нэгдэж, “Соёмбо даатгал” ХХК нэртэй болж өөрчлөгдсөн бол “Прайм женерал даатгал” ХХК нь “Тэнгэр даатгал” ХХК, “Гранд ко даатгал” ХХК нь “Гранд даатгал” ХХК болж нэрээ тус тус сольсон байна.

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо сүүлийн 5 жилд буюу 2006 оноос 2010 оны хооронд 8,5 дахин өссөн бөгөөд зөвхөн 2010 оныг 2009 онтой харьцуулахад 395 тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр нэмэгдсэн нь даатгалын салбарын өсөлтийн хурдац өндөр байгааг харуулж байна (График-1).




II. ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

2010 оны байдлаар даатгалын зах зээл дээр урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгө 56.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх 2009 оныхоос 15.6 тэрбум төгрөг буюу 37,96 хувиар нэмэгдсэн байна. Даатгагчдын нийт хөрөнгийн өсөлтийг сүүлийн 5 жилийн динамикаас харахад 2006 оноос хойш жилд дунджаар 20 хувийн өсөлттэй байсан бол 2010 онд 38 хувь болж өсөлтийн хурдац 1,9 дахин нэмэгдлээ. Энэ нь Хорооны 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 153 дугаар тогтоолоор 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн “Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 1 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 2 тэрбум төгрөг” байхаар баталсан буюу өмнөх хэмжээнээс 2 дахин нэмэгдүүлж тогтоосонтой холбоотой юм.

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн жилүүдэд тогтвортой өсч ирсэн байдал дараах графикаас харагдаж байна (График-2). Даатгагчдын нийт хөрөнгийн 2010 оны үзүүлэлтийг 2003 оныхтой харьцуулахад 4,4 дахин өссөн дүнтэй байна. Тухайлбал, 2003 онд даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 12.8 тэрбум төгрөг байсан бол 2005 онд 21.2 тэрбум төгрөг болж өсч, 2006 онд 20.8 тэрбум болж буурч, улмаар 2006 оноос хойш тасралтгүй өссөөр 2009 онд 41.1 тэрбум төгрөгт хүрч, улмаар 2010 онд 56.7 тэрбум төгрөг болсон байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгө



2010 онд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн болон урт хугацааны даатгалын компаниудыг нийт хөрөнгийнх нь хэмжээгээр жагсаахад “Монгол даатгал” ХХК 16.1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй буюу нийт зах зээлийн 28,3 хувийг эзэлж даатгалын байгууллагуудыг нийт хөрөнгийн хэмжээгээр тэргүүлж байгаа бол “Моннис даатгал” ХХК 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт зах зээлийн 1,8 хувийг эзэлж байна (Хүснэгт-2).

Хүснэгт-2

Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ

/сая төгрөгөөр/

д/д	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	“Монгол даатгал” ХХК	16 058,3	28,3
2	“Бодь даатгал” ХХК	5 072,0	8,9
3	“Тэнгэр даатгал” ХХК	4 310,2	7,6
4	“Практикал даатгал” ХХК	4 184,2	7,4
5	“Миг даатгал” ХХК	4 103,5	7,2
6	“Номин даатгал” ХХК	3 029,1	5,3
7	“Ард даатгал” ХХК	2 982,9	5,3
8	“Соёмбо даатгал” ХХК	2 437,6	4,3
9	“Нэйшнл лайф даатгал” ХХК	2 142,7	3,8
10	“Ган зам даатгал” ХХК	2 031,8	3,6
11	“УБ даатгал” ХХК	1 695,1	3,0
12	“Монгол траст холдинг даатгал” ХХК	1 677,5	3,0
13	“Улаанбаата хотын даатгал” ХХК	1 655,6	2,9
14	“Мөнх даатгал” ХХК	1 526,5	2,7
15	“Жонон даатгал” ХХК	1 408,5	2,5

16	“Гранд даатгал” ХХК	1 402,3	2,5
17	“Моннис даатгал” ХХК	1 046,1	1,8
	Дүн	56 763,9	100,0

2010 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниудын нийт хөрөнгийн 83,4 хувийг эргэлтийн хөрөнгө, 16,6 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлж байна. Нийт хөрөнгөнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь өндөр байгаагийн гол шалтгаан нь Хорооны 2008 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага” журмаар дүрмийн сан болон даатгалын нөөц сангийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хэлбэрээр байршуулах шаардлага давамгайлж байсантай холбоотой байна. 2010 оны байдлаар мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ, богино хугацаат хөрөнгө оруулалт нийлээд 42.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд нийт эргэлтийн хөрөнгийн 90,0 хувийг эзэлж, тайлант онд өмнөх оны мөн үеийнхээс 3,7 пунктээр өссөн дүнтэй гарсан байна. Нийт хөрөнгөнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь хэмжээ өссөн нь Хорооны 2009 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, мөн 2010 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын компанийн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалт, түүнд тавигдах шаардлага” зэрэг журмын хэрэгжилттэй холбоотой юм.

Даатгагчдын нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа эргэлтийн хөрөнгийн бүтцийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ хамгийн өндөр буюу дунджаар 69,4 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт дунджаар 14,4 хувь, дансны авлага дунджаар 9,0 хувь, бусад эргэлтийн хөрөнгө дунджаар 7,2 хувь байсан бөгөөд тайлант оны үзүүлэлтүүдийг 2009 оныхтой харьцуулахад эргэлтийн хөрөнгөнд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хувь буурч, харин богино хугацаат хөрөнгө оруулалтын хувь хэмжээ өссөн байна. Гэхдээ “богино хугацаат хөрөнгө оруулалт” гэдэг ойлголтонд 3 сараас дээш хугацаатай банкны хугацаат хадгаламжууд багтаж байгаа учраас эргэлтийн хөрөнгийн ихэнх хэсгийг үндсэндээ мөнгөн хөрөнгө бүрдүүлж байгаа юм (Хүснэгт-3).

Хүснэгт-3

Эргэлтийн хөрөнгийн бүтэц

/сая төгрөгөөр/

Эргэлтийн хөрөнгийн бүтэц	2006 он		2007 он		2008 он		2009 он		2010 он	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12510.4	70.8	15600.1	64.3	22162.2	74.8	23487.8	64.8	34241,1	72,38
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1749.9	9.9	3065.4	12.6	2862.2	9.7	7967.8	22.0	8560,4	18,10
Дансны авлага	1747.0	9.9	1979.8	8.2	2476.0	8.4	3754.2	10.4	3844,5	8,13
Бусад эргэлтийн хөрөнгө	1675.2	9.5	3625.2	14.9	2131.7	7.2	1024.9	2.8	659,9	1,39
Дүн	17682.5	100.0	24270.5	100.0	29632.1	100.0	36234.7	100.0	47305,9	100,0

2003 онд нийт хөрөнгийн 21,1 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байсан бол сүүлийн 6 жилийн хугацаанд нийт хөрөнгөн дэх эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувь хэмжээ тогтвортой буурч ирсэн. Гэвч 2010 онд энэ үзүүлэлт 4,9 пунктээр гэнэт өссөн дүнтэй гарсан нь Хорооны 2009 оны 153 дугаар тогтоолын дагуу даатгагчдын дүрмийн сангийн хөрөнгийн хэмжээг 2010 онд багтаж 2 дахин нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэнтэй холбоотой юм (График-3).

График-3



III. ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 5 жилийн байдлаар дүгнэж үзэхэд 2005-2007 онуудад эзэмшигчдийн өмч дунджаар 37,2 хувь, нөөцийн сан 56,7 хувь, нийт өр төлбөр 6,1 хувийг тус тус эзэлж байсан бол 2008 онд энэхүү бүтцэд нилээд өөрчлөлт гарч нөөцийн сан 43,8 хувь болж 18,9 пунктээр буурч, харин нийт өр төлбөр 18,9 пунктээр өссөн байна.

Нийт даатгалын салбарын өр төлбөр, эзэмшигчийн өмч ба нөөцийн санд эзэмшигчийн өмчийн эзлэх хувь 2009 онд 33,9 хувь байсан бол 2010 онд 44,3 хувь болж өмнөх оныхоос 10,4 пунктээр өсч, мөн нөөц сан 2009 онд 60,3 хувь байсан бол тайлант онд 51,3 хувь болж өмнөх оноос 8,9 пунктээр буурсан байна. Мөн түүнчлэн 2009 онд өр төлбөр нийт эзэмшигчийн өмч, өр төлбөр, нөөц сангийн 5,8 хувийг эзэлж байсан бол 2010 онд 4,3 хувийг эзлэх болж 1,5 пунктээр буурсан үзүүлэлт харагдаж байна. Даатгалын салбарын эзэмшигчийн өмчийн тайлант оны өсөлт нь Хорооны 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 153 дугаар тогтоолоор 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн “Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 1 тэрбум төгрөг, урт хугацааны

даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 2 тэрбум төгрөг” болгохоор шийдвэрлэсэнтэй холбоотой юм (Хүснэгт-4).

Хүснэгт-4


Даатгагчийн өр төлбөр, эзэмшигчийн өмч ба нөөцийн сан

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2006 он		2007 он		2008 он		2009 он		2010 он	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Өр төлбөр	1153.6	5.6	1785.3	6.3	8666.2	25.2	2390.5	5.8	2446.9	4.3
Нөөцийн сан	12198.3	58.7	17784.4	62.7	15033.9	43.8	24744.6	60.3	29174.7	51.4
Эзэмшигчийн өмч	7433.3	35.8	8808.2	31.0	10630.1	31.0	13920.6	33.9	25142.3	44.3
Дүн	20785.2	100.0	28377.9	100.0	34330.2	100.0	41055.7	100.0	56763.9	100.0

2008 онд даатгалын нөөц сан, эзэмшигчийн өмч, нийт өр төлбөрт нилээд их өрчлөлт орсон нь Хорооны 2008 оны 241 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагын мэдээллийн сангийн журам”-ын хавсралтын дагуу орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг балансын нөөцийн сангийн хэсгээс хасч, өр төлбөр хэсэг дэх урьдчилж орсон орлогоор бүртгэх болсонтой холбоотой юм. Энэхүү “Даатгалын байгууллагын мэдээллийн сангийн журам”-ыг сайжруулан боловсруулж “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам” болгон Хорооны 2009 оны 12 дугаар сарын 275 дугаар тогтоолоор баталсан. Шинээр боловсруулж мөрдсөн уг журмын дагуу орлогод тооцоогүй хураамж нь балансын “нөөц сан” гэсэн үзүүлэлтэнд орохоор болсон учраас 2009 онд нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид өр төлбөрийн эзлэх хувь өмнөх онтой харьцуулахад огцом буурсан дүр зураг харагдаж байсан (График-4).

График-4



IV. ДААТГАГЧИЙН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын хураамжийн нийт орлогын хэмжээ 31.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 8.37 тэрбум төгрөгөөр буюу 35,9 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс ердийн даатгалын хураамжийн орлого 31.5 тэрбум төгрөг болж, урт хугацааны даатгалын компанийн орлого 0.3 тэрбум төгрөг болсон байна.

2010 онд ердийн даатгалын компаниудын давхар даатгалын хураамжийн хэмжээ 7.5 тэрбум төгрөг, буцаасан даатгалын хураамж 0.2 тэрбум төгрөг, даатгалын цэвэр хураамжийн орлого 23.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Урт хугацааны даатгалын компанийн хувьд 0.1 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн болон 0.2 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлого төвлөрүүлсэн байна /График-5/.

График-5



2001 оноос 2010 он хүртэлх хугацаанд даатгалын нийт хураамжийн орлогын хэмжээ 26.63 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд тайлант онд өмнөх оны мөн үеийнхээс 8.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлтэнд өсөх хандлага ажиглагдаж байгааг харуулахаас гадна даатгуулагч иргэд, байгууллагуудын тоо өссөнтэй холбоотой юм.

2010 оны даатгалын нийт хураамжийн орлогыг ердийн болон урт хугацааны даатгалын хэлбэрүүдээр нарийвчлан авч үзэхэд хөрөнгийн даатгал өмнөх оны мөн үеийнхээс 17 964.4 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн даатгал 2 142.7 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 1 578.4 сая төгрөгөөр, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 1 072.8 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 242.8 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 686.9 сая төгрөгөөр, барилга угсралтын даатгал 974.1 сая төгрөгөөр, ачааны даатгал 390.6 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 36.1 сая төгрөгөөр, мал амьтадын даатгал 55.8 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 1.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, даатгалын салбарын

дүнгээр өмнөх оны мөн үеийнхээс 8 368.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй харагдаж байна (Хүснэгт-5).

Хүснэгт-5

Даатгалын хураамжийн орлогын хэмжээ даатгалын хэлбэрүүдээр

/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	Даатгалын нийт хураамжийн орлого /09.12.31/	Даатгалын нийт хураамжийн орлого /10.12.31/	Өөрчлөлт /+,-/
1.2. Хөрөнгийн даатгал	6 450,4	8246,8	1796,4
1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал	4 771,4	6914,1	2142,7
1.8. Агаарын хөлгийн даатгал	3 082,9	2342,6	-740,3
1.10. Хариуцлагын даатгал	3 078,6	4657	1578,4
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2 676,9	3749,7	1072,8
1.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	1 827,7	2070,5	242,8
1.11. Санхүүгийн даатгал	611,8	1298,7	686,9
1.5. Барилга угсралтын даатгал	394,7	1368,8	974,1
1.4. Ачааны даатгал	375,2	765,8	390,6
2.1. Хугацаат амьдралын даатгал	59,5	191,8	132,3
2.5. Эрүүл мэндийн даатгал	55,4	91,5	36,1
1.7. Мал амьтдын даатгал	13,5	69,3	55,8
1.6. Газар тариалангийн даатгал	1,3	0	-1,3
2.3. Хуримтлалын даатгал	0,3	1,3	1,0
2.4 Тэтгэврийн даатгал	0,0	0,6	0,6
Дүн	23 399,6	31 768,5	8 368,9

Даатгалын компаниудыг 2010 онд олсон даатгалын хураамжийн орлогын хэмжээгээр жагсаахад нийт хураамжийн орлогын 27,3 хувь буюу 8.7 тэрбум төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлсэн бол “Бодь даатгал” ХХК нь нийт хураамжийн орлогын 17,3 хувь буюу 5.5 тэрбум төгрөг, “Тэнгэр даатгал” ХХК нь нийт хураамжийн орлогын 12,4 хувь буюу 3.9 тэрбум төгрөг, “Миг даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 10,6 хувь буюу 3.4 тэрбум төгрөг, “Практикал даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 8,1 хувь буюу 2.6 тэрбум төгрөгийг тус тус бүрдүүлж, нийлбэр дүнгээр даатгалын зах зээлийн нийт 75,7 хувийг эзэлж байна. Харин “Моннис даатгал” ХХК нь тайлант оны эцэст байгуулагдсан тул даатгалын хураамжийн орлого төвлөрүүлээгүй байна (Хүснэгт-6).

Хүснэгт-6

Даатгалын компаниудын хураамжийн орлогын хэмжээ


/сая төгрөгөөр/

д/д	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	“Ард даатгал” ХХК	2 343,6	7,4
2	“Бодь даатгал” ХХК	5 510,3	17,3
3	“Ган зам даатгал” ХХК	641,4	2,0
4	“Гранд даатгал” ХХК	647,3	2,0


5	“Жонон даатгал” ХХК	232,8	0,7
6	“Миг даатгал” ХХК	3 381,1	10,6
7	“Монгол даатгал” ХХК	8 676,6	27,3
8	“Монгол траст холдинг даатгал” ХХК	4,8	0,0
9	“Моннис даатгал” ХХК	-	0,0
10	“Мөнх даатгал” ХХК	462,0	1,5
11	“Номин даатгал” ХХК	1 818,3	5,7
12	“Нэйшнл лайф даатгал” ХХК	285,2	0,9
13	“Практикал даатгал” ХХК	2 562,1	8,1
14	“Соёмбо даатгал” ХХК	930,4	2,9
15	“Тэнгэр даатгал” ХХК	3 939,4	12,4
16	“УБ даатгал” ХХК	166,1	0,5
17	“Уланбаатар хотын даатгал” ХХК	167,1	0,5
	Дүн	31768,5	100,0

Даатгалын нийт хураамжийн орлогын хэмжээг дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-тэй харьцуулахад 2001 оноос 2010 оны хооронд 0,32 хувиас 0,43 хувийн хооронд хэлбэлзэж ирсэн байна. Даатгалын хураамжийн орлогын хэмжээ ДНБ-д маш бага хувь эзэлж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт буюу улс ардын аж ахуйн томоохон салбаруудын өсөлт, хөгжилтэй холбоотой гэж үзэж байна. Даатгалын нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2009 онд 0,39 хувь байсан бол 2010 оны эцэст мөн адил 0,39 хувь буюу энэ үзүүлэлт өөрчлөгдөөгүй байна (График-6).

График-6



2008 онд нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого 7 977.6 мянган төгрөг байсан бол 2009 онд 8 657.1 мянган төгрөг болж 8,5 хувиар өсч, тайлант онд 11 766.1 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 3 109.0 мянган төгрөгөөр өссөн байна (График-7).



V. ДААТГАГЧИЙН НӨХӨН ТӨЛБӨР

2010 онд даатгалын компаниуд даатгуулагч иргэд, байгууллагуудад нийт 6.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 тэрбум төгрөг буюу 12,4 хувиар өссөн байна (График-8).

График-8



Даатгалын хураамжийн орлого болон даатгуулагчдад олгосон нөхөн төлбөрийн хэмжээг сүүлийн 10 жилийн байдлаар зэрэгцүүлэхэд 2001-ээс 2002 онд хураамжийн орлого бага зэрэг өссөн дүнтэй байхад даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ буурч байсан бол 2003 оноос хойших хугацаанд даатгуулагчдад олгосон нөхөн төлбөрийн хэмжээ хураамжийн орлогын өсөлтийг даган жил бүр өсөх болсон байна. Ингэхдээ олгосон нөхөн төлбөрийн өсөлтийн хурдац даатгалын хураамжийн орлогын жилийн өсөлтийн хурдацаас нилээд доогуур байсан учраас 2010 он гэхэд даатгалын хураамжийн орлого болон олгосон нөхөн төлбөрийн хоорондын зөрүү нилээд нэмэгдсэн байна.

Даатгалын нөхөн төлбөр олголтын сүүлийн 10 жилийн динамикийг харахад даатгуулагчдад олгосон нийт нөхөн төлбөр 2001 оноос хойш 5.0 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна (Хүснэгт-7).

Хүснэгт-7

Даатгуулагчид олгосон нөхөн төлбөр даатгалын хэлбэрүүдээр

/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	Даатгалын нөхөн төлбөр /10.12.31/	Эзлэх хувь
1.2. Хөрөнгийн даатгал	1 425,5	20,90
1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал	3 022,3	44,31
1.8. Агаарын хөлгийн даатгал	10,4	0,15
1.10. Хариуцлагын даатгал	224,1	3,29
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлыг даатгал	776,5	11,38
1.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	757,9	11,11
1.11. Санхүүгийн даатгал	419,6	6,15
1.5. Барилга угсралтын даатгал	89,0	1,30
1.4. Ачааны даатгал	38,4	0,56
2.1. Хугацаат амьдралын даатгал	15,0	0,22
2.5. Эрүүл мэндийн даатгал	30,7	0,45
1.7. Мал амьтадын даатгал	11,4	0,17
1.6. Газар тариалангийн даатгал	-	0,00
2.3. Хуримтлалын даатгал	-	0,00
Дүн	6 820,8	100,0

Өмнөх 2009 онд даатгуулагчдад олгосон нөхөн төлбөрийг даатгалын хэлбэр тус бүрээр харьцуулж үзэхэд авто тээврийн хэрэгслийн даатгал нийт нөхөн төлбөрийн 48,7 хувийг эзэлж байгаа бол үүний дараа хөрөнгийн даатгал 19,4 хувь, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 11,6 хувийг тус тус эзэлж байсан бол тайлант онд даатгуулагч иргэд, байгууллагуудад олгосон даатгалын нийт нөхөн төлбөрийн 44,3 хувийг авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал эзлэх болж, 20,9 хувийг хөрөнгийн даатгал, 11,38 хувийг гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал, 11,1 хувийг авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал тус тус эзэлж байна. Харин 2010 онд газар тариалангийн даатгал болон мал амьтдын даатгалаар нөхөн төлбөр олгогдоогүй байна (Хүснэгт-8).

Даатгалын компаниудын олгосон нөхөн төлбөрийн хэмжээ

/сая төгрөгөөр/


д/д	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	“Ард даатгал” ХХК	655,8	9,6
2	“Бодь даатгал” ХХК	530,6	7,8
3	“Ган зам даатгал” ХХК	59,7	0,9
4	“Гранд даатгал” ХХК	72,6	1,1
5	“Жонон даатгал” ХХК	215,8	3,2
6	“Миг даатгал” ХХК	499,4	7,3
7	“Монгол даатгал” ХХК	2 826,1	41,4
8	“Монгол траст холдинг даатгал” ХХК	0,4	0,0
9	“Моннис даатгал” ХХК	-	0,0
10	“Мөнх даатгал” ХХК	61,2	0,9
11	“Номин даатгал” ХХК	521,7	7,6
12	“Нэйшнл лайф даатгал” ХХК	45,7	0,7
13	“Практикал даатгал” ХХК	330,6	4,8
14	“Соёмбо даатгал” ХХК	179,6	2,6
15	“Тэнгэр даатгал” ХХК	731,8	10,7
16	“УБ даатгал” ХХК	42,8	0,6
17	“Улаанбаатар хотын даатгал” ХХК	47,0	0,7
	Дүн	6 820,8	100,0

Даатгалын компаниудыг даатгуулагчдад олгосон нөхөн төлбөрийн хэмжээгээр жагсаахад “Монгол даатгал” ХХК 2 826.1 сая төгрөгөөр тэргүүлсэн бөгөөд энэ нь даатгалын нийт нөхөн төлбөрийн 41,4 хувийг эзэлж байна. Харин “Монгол траст холдинг даатгал” ХХК нь хамгийн бага буюу 0.4 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон үзүүлэлттэй байхад тайлант оны эцэст тусгай зөвшөөрлөө авсан “Моннис даатгал” ХХК нь нөхөн төлбөр огт олгоогүй буюу үйл ажиллагаа явуулаагүй байна.

2010 онд даатгалын нөхөн төлбөрийн нийт хэмжээ 6.8 тэрбум төгрөгт хүрч, даатгалын нөхөн төлбөр болон даатгалын хураамжийн орлогын харьцаа 21,4 хувь болсон дүнтэй харагдаж байна.

Өмнөх оны байдлаар уг үзүүлэлт нь 23,5 хувь байсан тул тайлант онд энэ харьцаа 2,1 пунктээр буурсан дүнтэй гарлаа. Энэхүү бууралтын гол шалтгаан нь даатгалын хураамжийн орлогын нийт хэмжээ өмнөх оныхоос 1,4 дахин буюу 35,9 хувиар өссөн байхад даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс дөнгөж 1,1 дахин буюу 12,4 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна (График-9).

График-9



VI. ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

2007 онд даатгалын хохирол нөхөлтийн харьцаа 43,8 хувь, 2008 онд 30,4 хувь, 2009 онд 33,5 хувь, 2010 онд 34,0 хувь хүрч өмнөх оны мөн үеийнхээс 0,5 пунктээр өссөн байна (График-10).

График-10



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын даатгалын хохирол нөхөлтийн түвшингийн 2010 оны үзүүлэлтийг өмнөх оныхтой харьцуулахад даатгалын компаниуд дараах байдалтай байна (Хүснэгт-9).

Хүснэгт-9

Даатгалын хохирол нөхөлтийн түвшин

д/д	Даатгалын компаниудын нэрс	2009 он	2010 он	Өсөлт бууралт /пункт +,-/
1	“Ард даатгал” ХХК	39,3	45,1	5,8
2	“Бодь даатгал” ХХК	34,9	26,4	-8,5
3	“Ган зам даатгал” ХХК	12,9	10,4	-2,5
4	“Гранд даатгал” ХХК	0	39,3	0
5	“Жонон даатгал” ХХК	23,7	84,0	60,3
6	“Миг даатгал” ХХК	22,6	20,2	-2,4
7	“Монгол даатгал” ХХК	37,3	46,0	8,7
8	“Монгол траст холдинг даатгал” ХХК	1,8	1,3	-0,5
9	“Моннис даатгал” ХХК	0	0	0
10	“Мөнх даатгал” ХХК	27,4	16,3	-11,1
11	“Номин даатгал” ХХК	46,4	35,5	-10,9
12	“Нэйшнл лайф даатгал” ХХК	16,4	34,5	18,1
13	“Практикал даатгал” ХХК	21,7	18,4	-3,3
14	“Соёмбо даатгал” ХХК	42,7	24,7	-18,0
15	“Тэнгэр даатгал” ХХК	25,5	35,6	10,1
16	“УБ даатгал” ХХК	19,3	18,9	-0,4
17	“Улаанбаатар хотын даатгал” ХХК	28,1	31,7	3,6
	Нийт хохирол нөхөлтийн түвшин	33,5	34,0	0,5


Даатгалын компаниудын 2010 оны хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 5,8 пунктээр, “Жонон даатгал” ХХК 60,3 пунктээр, “Монгол даатгал” ХХК 8,7 пунктээр, “Нэйшнл лайф даатгал” ХХК 18,1 пунктээр, “Тэнгэр даатгал” ХХК 10,1 пунктээр, “Улаанбаатар хотын даатгал” ХХК 3,6 пунктээр тус тус өссөн байхад “Бодь даатгал” ХХК 8,5 пунктээр, “Ганзам даатгал” ХХК 2,5 пунктээр, “Миг даатгал” ХХК 2,4 пунктээр, “Монгол траст холдинг даатгал” ХХК 0,5 пунктээр, “Мөнх даатгал” ХХК 11,1 пунктээр, “Номин даатгал” ХХК 10,9 пунктээр, “Практикал даатгал” ХХК 3,3 пунктээр, “Соёмбо даатгал” ХХК 18,0 пунктээр, “УБ даатгал” ХХК 0,4 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

VII. АШИГТ АЖИЛЛАГАА

Даатгалын салбарын хэмжээгээр 2006 онд 1 187.0 сая төгрөг, 2007 онд 303.4 сая, 2008 онд 102.9 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажиллаж байсан бөгөөд 2009 онд хуримтлагдсан алдагдалгүй болж 1 779.0 сая төгрөг, 2010 онд 3 332.6 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан байна. Тайлант оны хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеийнхээс 1 553.6 сая төгрөгөөр өссөн байгаа нь даатгалын байгууллагууд нийтдээ 4 760.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласантай холбоотой юм (График-11).

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	- 1 187.0	- 303.4	- 102.9	1 779.0	3 332.6

График-11



Даатгалын салбарын хэмжээгээр 2009 онд даатгалын компаниуд нийт 2.4 тэрбум төгрөгийн тайлант үеийн цэвэр ашигтай ажилласан бол 2010 онд 4.7 тэрбум төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 2 дахин буюу 2.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

2009 онд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудыг тайлант үеийн цэвэр ашиг (алдагдлаар)-аар нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 1 133.8 сая төгрөгийн ашигтай ажиллаж нийт зах зээлийн 23,8 хувийг эзэлж байгаа бөгөөд “Практикал даатгал” ХХК 716.2 сая төгрөг буюу 15,0 хувь, “Номин даатгал” ХХК 577.5 сая төгрөг буюу 12,1 хувь “Миг даатгал” ХХК 480.7 сая төгрөг буюу 10,1 хувь, “Тэнгэр даатгал” ХХК 471.7 сая төгрөг буюу 9,9 хувь “Ган зам даатгал” ХХК 453.5 сая төгрөг буюу 9,5 хувийг тус тус эзэлж, эдгээр компаниуд нийт зах зээлийн 80,4 хувийг эзэлсэн байна.

2010 онд “Нэйшнл лайф даатгал” ХХК 141.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бол мөн “Моннис даатгал” ХХК нь 14.8 сая төгрөгийн алдагдлыг хүлээсэн байна. Энэ нь нийт даатгалын салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлсөн байна (Хүснэгт-10).

Хүснэгт-10

Даатгалын компанийн 2010 оны цэвэр ашиг (алдагдал)

д/д	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал	Эзлэх хувь /сая төгрөгөөр/
1	“Ард даатгал” ХХК	338.4	7.1
2	“Бодь даатгал” ХХК	383.1	8.0
3	“Ган зам даатгал” ХХК	453.5	9.5
4	“Гранд даатгал” ХХК	3.9	0.1

5	“Жонон даатгал” ХХК	16.5	0.3
6	“Миг даатгал” ХХК	480.7	10.1
7	“Монгол даатгал” ХХК	1,133.8	23.8
8	“Монгол траст холдинг даатгал” ХХК	61.2	1.3
9	“Моннис даатгал” ХХК	(14.8)	-0.3
10	“Мөнх даатгал” ХХК	63.7	1.3
11	“Номин даатгал” ХХК	577.5	12.1
12	“Нэйшнл лайф даатгал” ХХК	(142.4)	-3.0
13	“Практикал даатгал” ХХК	716.2	15.0
14	“Соёмбо даатгал” ХХК	23.1	0.5
15	“Тэнгэр даатгал” ХХК	471.7	9.9
16	“УБ даатгал” ХХК	130.7	2.7
17	“Улаанбаатар хотын даатгал” ХХК	63.2	1.3
	Дүн	4,760.0	100.0

VIII. ДААТГАЛЫН НӨӨЦ САН


Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч байсан дүр зураг харагдаж байна. Даатгалын нөөц сангийн 2010 оны үзүүлэлтийг 2006 оныхтой харьцуулахад 2,4 дахин өссөн дүнтэй байна. Тухайлбал, 2006 онд даатгалын нөөц сангийн хэмжээ 12.3 тэрбум төгрөг байсан бол 2007 онд 17.6 тэрбум төгрөг болж нэмэгдэж, 2008 онд 21.4 тэрбум болж өсч, улмаар 2009 онд 24.7 тэрбум төгрөгт хүрч, улмаар 2010 онд 29.1 тэрбум төгрөг болсон байна.

Тайлант оны эцэст даатгалын нөөц сангийн нийт үлдэгдэл 29 174.7 сая төгрөг байгаагаас ердийн даатгалын компанийн нөөц сангийн үлдэгдэл 29 081.5 сая төгрөг, урт хугацааны даатгалын нөөц сан 93.2 сая төгрөг байна.

Даатгалын нөөц сангийн байгуулалтад даатгалын актуарын аргуудыг түлхүү хэрэглэдэг болоход Хорооноос анхаарал тавьж байгаагийн зэрэгцээ нөөц сангаас даатгагч нарын хийсэн хөрөнгө оруулалт, зарцуулалт болон нөөц сангийн мөнгөн хөрөнгийн эрсдэл багатай байршуулалтын байдалд байнгын хяналт тавьж байна.

2010 онд даатгалын нөөц сангийн хэмжээ 29.1 тэрбум төгрөгт хүрснээр өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин буюу 4.4 тэрбум төгрөгөөр өссөн байна (График-12).


Даатгалын нөөц сан



IX. ДАВХАР ДААТГАЛ

2009 онд “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Прайм женерал даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иуд даатгалын эрсдэлээ давхар даатгаж нийт 6.0 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг гадаадын компаниудад төлсөн байсан бол 2010 онд “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иуд нийт 7.5 тэрбум төгрөгийг төлсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 1.5 тэрбум төгрөгөөр өссөн байна (График-13).

График-13



2010 онд гадаадын давхар даатгалын байгууллагуудад “Бодь даатгал” ХХК 2 890.5 сая төгрөг, “Монгол даатгал” ХХК 1 370.5 сая төгрөг, “Тэнгэр даатгал” ХХК 1 314.6 сая төгрөг, “Миг даатгал” ХХК 704.5 сая төгрөг, “Ард даатгал” ХХК 689.0 сая төгрөг, “Практикал даатгал” ХХК 244.5 сая төгрөг, “Номин даатгал” ХХК 129.0 сая төгрөг, “Гранд даатгал” ХХК 111.7 сая төгрөг, “Нэйшнл лайф даатгал” ХХК 107.0 сая төгрөгийг тус тус төлсөн байна

Х. ДААТГУУЛАГЧДЫН ТОО

2009 онд даатгалд нийт 341 738 даатгуулагч даатгуулсны 93,2 хувь нь хувь хүн, үлдэх 6,8 хувь нь хуулийн этгээд байсан бол 2010 онд даатгуулагчдын тоо 965 170 болж нэмэгдсэн байна. Тайлант онд нийт даатгуулсан хувь хүн, хуулийн этгээдүүдийн 62,7 хувь буюу 604,7 мянган даатгуулагчдыг “Миг даатгал” ХХК, 11,25 хувь буюу 108,6 мянган даатгуулагчдыг “Монгол даатгал” ХХК тус тус даатгасан байна. Даатгалын салбарын хэмжээгээр нийт даатгуулагчдын 82,8 хувийг 3 даатгалын компани даатгасан дүн харагдаж байна (Хүснэгт-11).

Хүснэгт – 11

Даатгалын гэрээний тоо

д/д	Даатгалын компаниуд	2009 он	ЭЗЛЭХ хувь	2010 он	ЭЗЛЭХ хувь
1	“Миг даатгал” ХХК	45 466	13.3	604 746	62.66
2	“Монгол даатгал” ХХК	63 693	18.6	108 581	11.25
3	“Мөнх даатгал” ХХК	13 943	4.1	85 867	8.90
4	“Номин даатгал” ХХК	38 866	11.4	35 642	3.69
5	“Моннис даатгал” ХХК	-	0.0	32 725	3.39
6	“Тэнгэр даатгал” ХХК (хуучин “Прайм женерал”)	12 126	3.5	23 646	2.45
7	“Ган зам даатгал” ХХК	6 317	1.8	20 151	2.09
8	“Соёмбо даатгал” ХХК (хуучин “Түшиг”)	14 283	4.2	16 247	1.68
9	“Практикал даатгал” ХХК	11 359	3.3	12 264	1.27
10	“Бодь даатгал” ХХК	24 014	7.0	8 342	0.86
11	“Ард даатгал” ХХК	16 962	5.0	7 390	0.77
12	“УБ даатгал” ХХК	68 302	20.0	7 273	0.75
13	“Улаанбаатар хотын даатгал” ХХК	26 307	7.7	1 918	0.20
14	“Нэйшнл лайф даатгал ХХК	82	0.0	139	0.01
15	“Жонон даатгал” ХХК	11	0.0	45	0.00
16	“Монгол траст холдинг даатгал” ХХК	5	0.0	79	0.00
17	“Соёмбо инк даатгал” ХХК	1	0.0	-	-
18	“Юу ай си даатгал” ХХК	1	0.0	-	-
19	“Гранд ко даатгал” ХХК	-	0.0	115	0.00
	Дүн	341 738	100.0	965 170	100.0

Тайлант онд даатгалын компаниудаас ирүүлсэн даатгалын гэрээний тоо буюу даатгуулагчдын талаарх мэдээний тоон үзүүлэлт хоорондоо ихээхэн зөрүүтэй, харьцуулж бодит байдалд дүгнэлт өгөхөд нилээд хүндрэлтэй байсан болно.

ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

XI. Даатгалын төлөөлөгч

2006 онд 22 даатгагчийн нийт 224 даатгалын төлөөлөгч байсан бол энэ тоо 2007 оноос эрс нэмэгдэж, 2007 онд 690 иргэн, 2008 онд 1167 иргэн, 2009 онд 1676 иргэн, 2010 онд 2061 иргэн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулсан байна.

2010 онд даатгагчдын тоо 17 болж, эдгээрээс 15 даатгалын компанид гэрээтэйгээр 2061 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа явуулсан дүнтэй байна (Хүснэгт-12).

Хүснэгт-12

Даатгалын төлөөлөгчдийн тоо

д/д		2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он
1	Даатгагч	22	15	16	18	17
2	Даатгалын компанийн салбар	48	91	120	129	138
3	Даатгалын төлөөлөгч	224	690	1 167	1 676	2061

Тайлант онд даатгалын компаниуд өөрсдийн даатгалын төлөөлөгчдийн үйл ажиллагаагаар дамжуулан нийт 19.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн бөгөөд үүнээс орон нутаг дахь даатгалын салбартай гэрээ байгуулан ажилладаг даатгалын төлөөлөгчдийн оруулсан даатгалын хураамжийн орлого 17.5 тэрбум төгрөгт хүрсэн байна (Хүснэгт-13).

Хүснэгт-13

Даатгалын төлөөлөгчөөр дамжуулан төвлөрүүлсэн хураамжийн орлого

/сая төгрөгөөр/

д/д	Даатгалын компаниуд	Компанийн хураамжийн хэмжээ	Эзлэх хувь	Төлөөлөгчөөр дамжиж олсон орлого	Эзлэх хувь
1	“Ард даатгал” ХХК	2 343,6	7,4	2 015,0	10,8
2	“Бодь даатгал” ХХК	5 510,3	17,3	965,4	5,2
3	“Ган зам даатгал” ХХК	641,4	2,0	421,6	2,3
4	“Гранд даатгал” ХХК	647,3	2,0	-	-
5	“Жонон даатгал” ХХК	232,8	0,7	647,3	3,5
6	“Миг даатгал” ХХК	3 381,1	10,6	2 471,2	13,3
7	“Монгол даатгал” ХХК	8 676,6	27,3	8 676,6	46,6
8	“Монгол траст холдинг даатгал” ХХК	4,8	0,0	4,8	0,0
9	“Моннис даатгал” ХХК	-	0,0	-	-
10	“Мөнх даатгал” ХХК	462,0	1,5	0,0	0,0
11	“Номин даатгал” ХХК	1 818,3	5,7	995,1	5,3
12	“Нэйшнл лайф даатгал” ХХК	285,2	0,9	0,0	0,0
13	“Практикал даатгал” ХХК	2 562,1	8,1	1 878,9	10,1
14	“Соёмбо даатгал” ХХК	930,4	2,9	915,9	4,9
15	“Тэнгэр даатгал” ХХК	3 939,4	12,4	0,0	0
16	“УБ даатгал” ХХК	166,1	0,5	119,3	0,6
17	“Улаанбаатар хотын даатгал”	167,1	0,5	167,1	0,9

	ХХК				
	Дүн	31768,5	100,0	18 621.7	100,0

“Монгол даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгчдийн хуримтлуулсан даатгалын хураамжийн орлогын хэмжээ нийт төвлөрүүлсэн орлогын 20,2 хувийг эзэлж тэргүүлсэн бол “Моннис даатгал” ХХК нь одоогоор даатгалын төлөөлөгчгүй ажилласан байна.

ХII. Даатгалын зуучлагч компаниуд

2007 онд Даатгалын зуучлагч компани 2, 2008 онд 4, 2009 онд 5, 2010 онд 9 компани үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тайлант онд шинээр “Ренессанс групп” ХХК, “Монголиан брокерс интернэшнл” ХХК, “Жомолхари” ХХК, “Лоялти солюшн” ХХК-иуд шинээр тусгай зөвшөөрөл авсан байна.

Тайлант онд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 193.6 сая төгрөг болсон бөгөөд үүнээс даатгалын зуучлалын орлого 177.3 сая төгрөг, бусад орлого 16.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна (Хүснэгт-14).

Хүснэгт-14

Даатгалын зуучлалын орлого

/сая төгрөгөөр/

д/д	Даатгалын зуучлагч компаниуд	Даатгалын зуучлалын орлого	Эзлэх хувь
1	“Асимон брокерс” ХХК	35,8	20,2
2	“Аме” ХХК	23,5	13,3
3	“Ачит ундарга” ХХК	24,9	14,0
4	“Лоялти солюшн” ХХК	34,6	19,5
5	“Эм Жи Ай Би” ХХК	23,8	13,4
6	“Скай-Эрдэнэ” ХХК	22,7	12,8
7	“Ренессанс групп” ХХК	12,0	6,8
8	“Жомолхари” ХХК	0	Үйл ажиллагаа явуулаагүй
9	“Монголиан интернэшнл” ХХК	0	Үйл ажиллагаа явуулаагүй
	Дүн	177,3	100,0

“Асимон брокерс” ХХК нь даатгалын зуучлалын орлогын 20,2 хувийг эзэлж тэргүүлсэн бол “Лоялти солюшн” ХХК 19,5 хувь эзэлж, нийт зах зээлийн 40,0 хувийн орлогыг эдгээр даатгалын зуучлагчид эзэлсэн байна.

ХIII. Даатгалын хохирол үнэлэгч компаниуд

2009 онд 2 даатгалын хохирол үнэлэгч байсан бол 2010 онд шинээр 4 компани нэмэгдэж нийтдээ даатгалын хохирол үнэлэгчдийн тоо 6 болсон. “Вендо” ХХК, “Тэрэгэ эстимейт” ХХК, “Файн эстимейт” ХХК, “Мега марз” ХХК-иуд даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан байна.

Тайлант онд нийт үндсэн үйл ажиллагааны орлого 119.9 сая төгрөг, үүнээс даатгалын хохирол үнэлгээний орлого 36.0 сая төгрөг, бусад орлого 83.9 сая төгрөг эзэлж байна (Хүснэгт-15).

Хүснэгт-15

Даатгалын хохирол үнэлгээний орлого

/сая төгрөгөөр/

д/д	Даатгалын хохирол үнэлэгч компаниуд	Даатгалын хохирол үнэлгээний орлого	Эзлэх хувь
1	“Бест эстимэйт” ХХК	14,3	39,7
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	4,9	13,6
3	“Файн эстимэйт” ХХК	3,5	9,8
4	“Итгэлт эстимэйт” ХХК	7,9	21,9
5	“Мега марз” ХХК	5,4	15,0
6	“Вендо” ХХК	0	Тайлан ирүүлээгүй
	Дүн	36,0	100,0

“Бест эстимэйт” ХХК, “Итгэлт эстимэйт” ХХК- иуд нийлээд нийт даатгалын хохирол үнэлгээний орлогын 61,6 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр компаниуд нь 2009 онд тусгай зөвшөөрлөө авсан бөгөөд бусад хохирол үнэлэгч компаниудыг бодвол үйл ажиллагаа нь жигдэрч эхэлсэнтэй холбоотой юм.

ХИҮ. ОЛОН УЛСЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Дэлхийн улс орнуудад тохиолдсон 2008-2009 оны санхүү, эдийн засгийн хямрал ихээхэн хүндрэл бэрхшээл учруулсан ч байдал аажмаар сайжирч, 2010 онд олон улсын даатгалын зах зээл дээрх бизнесийн үйл ажиллагаа идэвхжин сэргэх хандлага ажиглагдсан. Ялангуяа, Азийн бүс нутгийн орнуудын эдийн засгийн хөгжилд зарим нааштай ахиц гарсан бөгөөд үүнийг дагаад даатгалын салбарын хөгжилд өсөлт гарч эхэлсэн байна.

Дэлхийн хөгжилтэй орнуудын хувьд санхүүгийн хямралаас гарах байдал харьцангуй удаашралтай явагдаж байгаа бол хөгжиж байгаа, ялангуяа Азийн орнуудын хувьд эдийн засгийн сэргэлт нэлээд эрчтэй явагдаж байгаа талаар олон улсын шинжээчид дурьдаж байна.

Олон улсын практикт даатгалын салбарын хөгжлийг харуулахдаа тухайн улс орны дотоодын нийт бүтээгдэхүүнд даатгалын хураамжийн орлогын эзлэх хувь хэмжээгээр харьцуулан тодорхойлдог жишиг тогтсон байдаг бөгөөд энэ харьцуулалтыг дэлхийн тэргүүлэгч хөгжилтэй зарим улс орон болон Азийн бус нутгийн голлох орнуудын жишээн дээр дараах хүснэгтэд харууллаа (Хүснэгт-16).

Хүснэгт-16

Дотоодын нийт бүтээгдэхүүнд даатгалын хураамжийн эзлэх хувь хэмжээ

/хувиар/

Улсын нэр	Арилжааны даатгал бүгд	Амьдралын даатгал	Ердийн даатгал
Дэлхийн дундаж	7,0	5,2	1,8
Англи	12,9	10,1	2,8
Солонгос	10,4	8,2	2,2
Япон	9,9	7,8	2,1
Америк	8,0	7,0	1,0

Сингапур	6,8	5,1	1,7
Энэтхэг	5,2	4,6	0,6
Малайзи	4,4	2,9	1,6
Тайланд	4,0	2,4	1,6
Хятад	3,4	2,3	1,1
Индонези	2,0	1,6	0,5
Филиппин	1,5	1,0	0,5
Вьетнам	1,5	0,7	0,8
Шри-Ланк	1,4	0,6	0,9
Пакистан	0,7	0,3	0,4
Монгол	0,4	0,0	0,4

Дээрх хүснэгтээс харахад Монгол Улсын даатгалын зах зээлийн хөгжил манай бүс нутгийн орнуудынхаас нилээд хоцорч байгаа нь тодорхой байна. Дэлхийн дундажаар улс орны даатгалын хураамжийн хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 7 орчим хувийг эзэлж байдаг бол манай оронд энэ үзүүлэлт 0,4 хувьтай байгаа нь даатгалын зах зээл сул хөгжсөнийг харуулж байна.

Мөн түүнчлэн олон улсын практикт тухайн орны даатгалын зэх зээлийн хөгжлийг нэг хүн амд оногдох даатгалын хураамжийн хэмжээгээр харьцуулан харуулсан байдаг. Жишээ нь энэхүү үзүүлэлт дэлхийн дундажаар нэг хүнд 595 ам доллар оногдож байхад Монголын нэг хүн амд өнөөдрийн байдлаар 8.4 ам доллар ногдож байгаа нь нэлээд доогуур үзүүлэлт юм (Хүснэгт-17).

Хүснэгт-17

Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлогын хэмжээ

/ам доллараар/

Улсын нэр	Арилжааны даатгал бүгд	Амьдралын даатгал	Ердийн даатгал
Дэлхийн дундаж	595	446	149
Англи	4479	3494	985
Япон	3979	3143	836
Америк	3710	3246	464
Солонгос	1890	1489	401
Малайзи	219	144	75
Тайланд	197	118	79
Хятад	121	82	39
Энэтхэг	55	48	7
Индонези	50	40	10
Вьетнам	18	8	10
Монгол	8	0	8

Дээрх байдлаас дүгнэлт хийж, Монгол Улсын арилжааны даатгалын салбарыг цаашид эрчимтэй хөгжүүлэхэд төрөөс бодлогын хэмжээнд анхаарч ажиллах шаардлагатай байна.

ХҮ. ДҮГНЭЛТ

Даатгалын байгууллагын санхүүгийн мэдээллээс харахад даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 1,2 дахин нэмэгдэж даатгалын

хохирол үнэлэгч, даатгалын зуучлагч шинээр өсөн нэмэгдэж байгаа нь энэ зах зээлийн цар хүрээний өсөлтийн хурдацыг илтгэж байна.

Даатгалын зах зээл дээр 2010 онд үйл ажиллагаа явуулсан даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид нийт 32 082.0 сая төгрөгийн орлого олсон байна. Энэхүү орлогын 31483.3 сая төгрөг буюу 98,1 хувийг ердийн даатгалын компаниуд, 285.2 сая төгрөг буюу 0,9 хувийг урт хугацааны даатгалын компани, 193.6 сая төгрөг буюу 0,6 хувийг даатгалын зуучлагч компаниуд, 119.9 сая төгрөг буюу 0,4 хувийг даатгалын хохирол үнэлэгч компаниудын олсон орлого тус тус бүрдүүлсэн байна.

Даатгагчийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 15.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант үеийн цэвэр ашиг 4.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 2.3 тэрбум төгрөгөөр өссөн нь даатгалын байгууллагуудын санхүүгийн чадавхи нэмэгдэж байгааг харуулахаас гадна салбарын хэмжээнд ашигтай ажиллаж байгаа нь аливаа эрсдэлийг даван туулах хандлага, чадвар нэмэгдэж байна гэж дүгнэхээр байна.

Даатгалын салбарын 2010 оны нэгдсэн үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдийн үзүүлэлтүүдтэй харьцуулж үзэхэд даатгалын зах зээлийн тэлэлт явагдаж байгааг харж болохоор байна.

Дотоодын даатгалын салбар нь олон улсын даатгалын зах зээлийн жишигт хүрэхийн тулд эрчимтэй хөгжиж эхэлж байгаа салбарын хувьд цаашид ч тэлэлт үргэлжлэн явагдах хандлага ажиглагдаж байна.